

Улаанбаатар чуулгын "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлт

2020 оны 12 дугаар сарын 21-ны өдөр

Улаанбаатар хот

	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил арга хэмжээ	Төлөвлөсөн албан хаагчийн тоо	Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо	Эх үүсвэр		Биелэлт
				Дотоод	Гадаад	
A.	Анхан шатны сургалт					
1	Шинэ ажилчдад зориулсан танилцуулах	Тухай бүр	6	+		Шинээр ажилд орсон дуучин Э.Дашням, бүжигчин О.Ганзаяа, Д.Ичинхорлоо, эвэр бүрээ хөгжимчин А.Жамъянпүрэв, ёочин хөгжимчин Ц.Энхмаа, цохивор хөгжимчин Н.Билгүүн, гоцлол дуучин С.Эрдэнэцэцэг нарт байгууллагын дотоодод мөрдөгддөг дүрэм журам, байгууллагын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогийн талаар танилцуулах сургалтыг зохион байгуулж ажилласан.
2	Чуулгын хүрээнд хэрэгжиж байгаа дүрэм журмын сургалт	Бүх албан хаагчид	Бүх албан хаагчид	+		Байгууллагын үйл ажиллагааны дотоодод мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журмын сургалтыг хүний нөөцийн менежер Л.Одгэрэл 9 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж ажиллалаа. Тус сургалтанд жил бүр тус байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Нийслэлийн Иргэдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж болон Улаанбаатар чуулгын дүрэм, чуулгын даргын байгууллагын дотоод ажлын хэрэгцээнд зориулан баталсан журмуудын жагсаалт, мэдээллийн санг баяжуулсан талаарх мэдээллийг хүргэв. Тэдгээрээс онцлон чуулгын даргын тушаалаар шинэчлэн баталсан байгууллагын дотоод журамд орсон өөрчлөлтүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн. Тус сургалтанд 59 албан хаагч хамрагдсан.
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт	Бүх албан хаагчид	42	+		Байгууллагын ёс зүйн хорооноос чуулгын уран бүтээлчид, ажилтан, албан хаагчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 2020 оны төлөвлөгөөт ажлын хүрээнд онлайн сургалтыг Монгол лектор төвтэй хамтран "Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт өв" сэдвээр 2020 оны 3 дугаар 13-ны өдөр зохион байгуулсан. Сургалтанд чуулгын нийт албан хаагчдын 68 хувь нь оролцлоо.

Б. Дунд шатны сургалт					
4	Бакалавр, магистр, докторын зэрэг авах чиглэлээр мэргэжлийн чиглэлийн сургуульд элсүүлэх, суралцах нөхцлөөр хангах	4	9	+	Бакалавр, магистр, докторын чиглэлээр мэргэжлийн сургуульд элссэн, суралцаж байгаа албан хаагчдад суралцах нөхцлийг хангаж, ажлын цагийн зохицуулалтыг хийж, ачааллыг тэнцвэржүүлж ажилласан. Үүнд : Бакалаврын сургалтанд тонмейстр Ц.Батцэнгэл /СУИС мэргэжлийн тонмейстрээр/ суралцаж 2021 оны 1-р сард төгсөнө. Дизайнер Г.Чимэд /ХУИС англи хэлний оройн ангид /, архивын эрхлэгч Б.Сувд-Эрдэнэ /Тэнгэр дээд сургууль/, ёочин хөгжимчин Ц.Энхмаа /Соёл урлагийн их сургууль/, морин хуур хөгжимчин Т.Санжаажамц /Соёл урлагийн их сургууль/, бүжигчин О.Оюун-Эрдэнэ /Монгол улсын консерватори/ нар, магистрын сургалтанд гоцлол дуучин С.Ганзориг Удирдлагын Академид суралцаж 2020 оны 6 дугаар сард амжилттай төгссөн. Гоцлол дуучин Э.Дашням Соёл урлагийн их сургуульд урилгаар дуулах урлагийн мэргэжлийн багш, МУГЖ Ц.Чулуунцэцэгийн удирдлага дор элсэн суралцаж байна. Туслах удирдаач, их хуур хөгжимчин Б.Эрхэмбаяр Монгол Улсын Консерваторийн удирдаач багш, МУУГЗ Ч.Чинбатын удирдлага дор суралцаж эхлээд байна.
5	Монголын урлагийн зөвлөлийн дэргэдэх Соёл урлагийн залуу манлайлагчийн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах	2	1	+	Шанз хөгжимчин Б.Гэрэлтуяа Урлагийн зөвлөлийн дэргэдэх Соёл урлагийн залуу манлайлагчийн 1 жилийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж амжилттай төгссөн. Дээрх албан хаагчдыг суралцах боломжоор хангахын тулд ажлын цагийн зохицуулалтыг хийж, чөлөөтэй хугацаанд ажлын байрыг хэвээр хадгалж ажилласан болно.
В. Ахисан шатны сургалт					
6	Цинэ уран бүтээл туурвих, бие даасан тайлан тоглолт хийлгэх хэлбэрээр уран бүтээлчдийн хөрвөх болон өрсөлдөх ур чадварыг сайжруулах	Уран бүтээлчид	3	+	Гоцлол хөгжимчин, МУСТА, хийлч Ч.Дэлгэрцэцэг сонгодог урлагийг хөгжүүлэх, залуучуудад урам зориг нэмэх, үзэгчиддээ шинэлэг хэв маягийг хүргэж тэдэнд хийл хөгжмийн ертөнцийг ойлгуулах зорилгтой цоо шинэ классик поп жанрын "NEVER ENOUGH" тоглолт, морин хуур хөгжимчин МУСТА, А.Мөнгөний "Морин хуурын концерт"-ыг Монголд анх удаа, мөн бүжгийн багш, Д.Баярт, бүжигчин Б.Норовбанзад нарын хамтарсан "RED" гэр бүлийн тоглолтыг 2020 оны 3-4 дүгээр улиралд багтаан үзэгчдийн хүртээл болгохоор төлөвлөөд байсан бөгөөд дэлхий даяар тархсан цар тахлын хөл хорионы улмаас эдгээр тоглолтууд тодорхойгүй хугацаагаар хойшлогдон, олны хүртээл хараахан болж амжаагүй байна. Хэдий хөл хориотой тоглогдож амжаагүй ч дээрх тоглолтуудын бэлтгэл ажил 100 хувь хангагдаж, чуулгын зүгээс гоцлоочдын тоглолтын бэлтгэл, сургуулилтыг хангаж ажилласан.

7	Удирдах дээд байгууллагуудаас зарласан сургалтанд албан хаагчдыг хамруулах	Заасан албан хаагч	47		+	“Жендер ба хүний эрх” сургалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй” онлайн сургалт, “Хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд MS EXCEL программын сургалт, Монголын ирээдүйн хөгжлийн үндэсний төв”-ийн “Дотоод хяналтын ажилтан” бэлтгэх сургалтанд дотоод хяналт хийх арга зүй эзэмших зэрэг гадаад эх үүсвэрээс зохион байгуулагдсан 18 удаагийн сургалтанд нийт давхардсан тоогоор 47 албан хаагч хамрагдсан.
Г. Ерөнхий сургалтууд						
8	Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт	6	3 + 8		+	Нийслэлийн архивын ерөнхий газрын сургалт архив албан хэрэг хөтлөлтөнд мэдээлэл технологи нэвтрүүлэх арга зүй, нийслэлийн архивын ерөнхий газрын цахим архив сургалт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг албан хэрэг хөтлөлтийн анхан шатны баримт бичиг бүрдүүлэх тухай сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулсан.
9	Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, бүтээлч сэтгэлгээ, харилцааны ур чадварын сургалт	Бүх албан хаагчид	1 удаа		+	Чуулгын уран бүтээлчид, ажилтан, албан хаагчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 2020 оны төлөвлөгөөт ажлын хүрээнд онлайн сургалтыг Монгол лектор төвтэй хамтран “Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт өв” сэдвээр 2020 оны 3 дугаар 13-ны өдөр зохион байгуулсан. Сургалтанд чуулгын нийт албан хаагчдын 68 хувь нь оролцлоо.
10	Сошиал нэтворкийн зөв хэрэглээ	Бүх албан хаагчид			+	
11	Оффисын хэрэглээний программ ашиглалтыг сайжруулах сургалт	Захиргаа албан хаагчид	58		+	“Захиргааны албан хаагчдад зориулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” дадлагажих сургалт, “Улаанбаатар чуулгын дотоод журам”-ыг шинэчлэн баталсан тухай онлайн мэдээлэл сургалт, “Сэтгэл хөдлөл, харилцааны EQ хөгжүүлэх” хувь хүний хөгжлийн онлайн сургалт, захиргааны албан хаагчдад зориулсан “Powerpoint, excel-ийн хэрэглээний ахисан түвшин”-ий сургалтыг байгууллага дотооддоо зохион байгуулж ажилласан бөгөөд чуулгын албан хаагчид тус сургалтуудад 85 хувийн ирцтэй хамрагдсан байна.
12	Элдэв донтолт болон түүнээс гарах арга замууд, ажлын байран дах эрүүл зөв хооллолт	Бүх албан хаагчид	38		+	“Хэрэглээний боловсролын төв” ТББ-тай хамтран “Иргэн бүрт Эрүүл мэнд” уриан дор “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал, зуршил” сэдэвт сургалтыг 9 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтанд 38 албан хаагч хамрагдаж, албан хаагчид өөрийн сонирхсон асуултаа асууж, харилцан яриа өрнүүлсэн маш үр дүнтэй сургалт боллоо.

13	Спортын төрлийн дугуйлан секцэд хамруулах нөхцлийг бүрдүүлэх	Бүх албан хаагчид	55	+	Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Бүжиг ангийн хамт олны санаачлагаар 1.3.5 дах өдрийн өглөө иогийн дасгалын, ажлын байран дах хөдөлгөөнт дасгалын сургалтыг зохион байгуулж ажилласан.
14	Гамшгаас хамгаалах арга зүйн талаар сургалт өдөрлөгийг хийх, хөдөлмөр хамгааллын сургалт	Бүх албан хаагчид	Бүх албан хаагчид	+	“Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дадал олгох” онлайн сургалт, мөн тайз техникийн ажилчдад өдөр бүр хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагааны журам, цахилгаан хэрэгсэлтэй ажиллах зааварчилгаа, өргөх буулгах механизмтай ажиллах зааварчилгаа, галын аюулгүй байдлын зааварчилгаа, багаж хэрэгсэл тэй ажиллах зааварчилгаа зэргийг тогтмол өгч, гарын үсэг зуруулж, ажилд гаргаж хэвшсэн. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас 2020 онд тайзнаа зохион байгуулагддаг ажлууд эрс цөөрсөн бөгөөд энэхүү ажлууд дээр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн тохиолдол гараагүй.

Танилцсан:
Дарга



Р.Мөнхсайхан

Биелэлт гаргасан:
Хүний нөөцийн менежер

Л.Одгэрэл